



МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/05

Улаанбаатар хот

Техникийн комиссын бүрэлдэхүүнийг
шинэчлэн томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.10, "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын дүрмийн 4 дүгээр хэсгийн 4.10.6, 6 дугаар хэсгийн 6.2, Хөдөлмөрийн дотоод журмын 3 дахь хэсгийн 3.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын автомашин, техник тоног төхөөрөмжийн ашиглалт, хамгаалалт, эвдрэл гэмтэлд дүгнэлт өгч шийдвэр гаргах үүрэг бүхий техникийн комиссыг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн томилсугай.

Комиссын дарга:

Барилгын инженер

Гишүүд:

Тохижилт үйлчилгээний ахлах мэргэжилтэн

Эдийн засагч

Мастер

Нарийн бичгийн дарга:

Ашиглалтын инженер


2. Техникийн комиссын ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

3. Комиссын ажлын удирдамж, төлөвлөгөө, биелэлттэй тухай бүрд нь танилцаж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Комиссын даргад үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/11 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ЦОГТГЭРЭЛ



215030005

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын
даргын 2021 оны 01 сарын 11-ны
өдрийн 1105 дүгээр тушаалын хавсралт



Техникийн комиссын ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Монгол Наадам Цогцолбор” ОНӨТҮГ-ын Техникийн комиссын үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Байгууллагын автомашин, хөдлөх бүрэлдэхүүн, автомашины нөөц сэлбэг, бензин, шатах тослох материалын зарцуулалтад хяналт тавьж, шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангах ба техникийн комиссын акт /дүгнэлт/- ийг бүрэн бичиж, баталгаажуулан, шинээр сэлбэг хэрэгслийг сольж тавих болон хуучин сэлбэг хэрэгслийг хураан авах, устгах журмын дагуу ажиллана.

1.3. Техникийн комиссын үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль, техниктэй холбогдон гарсан тогтоол, дүрэм, журам зэргийг мөрдлөг болгон ажиллана.

Хоёр. Техникийн комиссын бүтэц бүрэлдэхүүн

2.1. Техникийн комисс нь таваас доошгүй сондгой тооны гишүүдтэй байх бөгөөд Комиссын бүрэлдэхүүнийг Газрын даргын тушаалаар албан тушаалын нэрээр томилно.

2.2. Техникийн комиссын гишүүдийн дундаас техникийн комиссын нарийн бичгийн даргыг сонгож томилно. Техникийн комиссын нарийн бичгийн дарга нь тухайн тоног төхөөрөмжийг хариуцсан инженер-мэргэжилтэн байвал зохино.

2.3. Техникийн комиссын бүрэлдэхүүнд орсон албан тушаалтан хүндэтгэх шалтгаанаар эзгүй үед тэдгээрийн орлогч буюу түүний албан үүргийг гүйцэтгэж байгаа ажилтан хуралдаанд оролцож санал дүгнэлтээ гаргана.

Гурав. Техникийн комиссын гишүүдийн эрх, үүрэг

3.1. Техникийн комиссын дарга нь хуралдааныг товлон, хорооны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

3.1.1. Техникийн комиссын хуралдааны тэмдэглэл, шийдвэрт гарын үсэг зурах;

3.1.2 Техникийн комиссын хуралдаанд оролцох, шийдвэр гаргахад өөрийн саналыг өгч оролцох;

3.1.3 Хуралдааныг товлон, техникийн комиссын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах;

3.2. Техникийн комиссын нарийн бичгийн дарга нь хуралдааныг зарлан мэдээлэх, зохион байгуулах, техникийн ажиллагаанд баримтлах хууль, тогтоомж, бүрдүүлсэн баримтуудыг гишүүдэд танилцуулах, мэдээллээр хангах, тухайн үйл

ажиллагаатай холбоотой баримт, материалыг бүрдүүлэн тэмдэглэл хөтлөх, баримтжуулах, хадгалах.

Дөрөв. Техникийн комиссын үйл ажиллагаа

4.1. Худалдаж авсан болон шилжиж ирсэн /захирамж, тушаал, шийдвэрээр/ автомашинуудыг комисс хүлээлцэж, тусгай маягт-"Автомашин хүлээлцэх акт"-аар жолооч нарт хүлээлгэн өгч, техникийн комиссын бүрэлдэхүүн гарын үсэг зурж баталгаажуулан, автомашинуудад хувийн хэрэг хөтлөн ажиллана.

4.2. Автомашин аваар осолд орж эвдэрсэн үед автомашины эвдрэлийг тодорхойлж үнэлгээ хийж, байгууллагад учирсан хохирлыг барагдуулах техникийн комиссын дүгнэлт гаргаж ажиллана.

4.3. Авто баазын тээврийн хэрэгсэл, автомашинуудын шатахуун, зарцуулалтын жишиг нормыг эрх бүхий дээд байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрийн дагуу батлан мөрдөх, өөрчлөлт орсон тухайн үед техникийн комиссын гишүүд хурлаар зөвлөлдөж өөрчлөлт хийж ажиллана.

4.4. Тээврийн хэрэгслүүдийн ашигласан жил, эдэлгээ, ашиглалтын явцаас шалтгаалан шатах, тослох материалын зарцуулалт тогтоосон норм хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж байгаа тохиолдолд "Автомашин шатахуун зарцуулалтын нормыг тооцох заавар"-ын дагуу тодорхойлж газрын даргад танилцуулна.

4.5. Техник тоног төхөөрөмж гэдэгт:

4.5.1. Компьютер /Суурин болон зөөврийн компьютер, түүний дагалдах хэрэгсэл, өнгөт болон хар принтер, АЗ принтер, баримт үдэгч, зургийн аппарат, гагнуурын аппарат, гар станц, хий хураагуур, машины байрлал тогтоогч, нийтийн бие засах газар /зуны, өвлийн/, автомат угаалгын машин, дохиолол хамгаалалт, хяналтын камер /дэлгэц, гар, хатуу диск, planet, багана, антейн, свич, тог тогтворжуулагч, автомат/, ЛЕД /дэлгэц, удирдлагын төхөөрөмж, компьютер, самбар, кабелийн багц/

4.5.2. Цахилгаан тоног төхөөрөмж /цахилгаан автобус, эко халаалт, шарах шүүгээ, аяга таваг ариутгагч, төмс шарагч, том жижиг электрон жин, телевизор, 12 гэрийн цахилгааны самбар кабель, хөлдөөгч, мах хэрчигч машин, заалны шилэн хаалгатай хөргөгч, нийтийн хоолны ус буцалгагч, махны жижиг машин, хоол халуун байлгагч, хөргөгч, цахилгаан зуух, богино долгионы зуух, цахилгаан үүсгүүр/

4.5.3. Цахилгааны шит /дундын, хэрэглэгчийн/, кабель, гадна гэрэлтүүлгийн шон, 64 гэрлийн удирдлагын самбар, гэрэлтүүлгийн шонгийн кабель,

4.5.4. Хөгжим /караказ, утастай микрофон, хайрцаг, тавцан, батерей, тоон пульт, чанга яригч, чадлын өсгөгч, зүү тогтоогч, утасгүй микрофон, микрофоны хөл, дууны процессор, тоглуулагч, тэжээлийн удирдлага, цахилгаан самбар, хөгжимний хайрцагнууд, кабелийн багц, салаалагч кабель/

4.5.5. Гэрэл /led par, led mac, sharp/, гэрлийн удирдлага, пүшик, гэрлийн цахилгаан самбар, гэрлийн кабель багц, хайрцагнууд/

4.5.6. Зөөврийн цахилгаан үүсгүүр /кабель, сэлгэн залгагч, хуваарилах самбар/

4.5.7. Радио узель /өсгөгч фульт, зурвасын хуваарилагч, чанга яригч, суурин микрофон, зөөврийн компьютер, флаш уншигч, хайрцаг, кабель, тэжээлийн кабель, тог баригч, хоолой, хайрцаг/ хамаарна.

4.6. Автомашин болон техник тоног төхөөрөмжийн эвдрэлд техникийн комиссын гишүүд цахим файл хэлбэрээр зураг авч баримтжуулан, комиссын хурлаар зөвлөлдөж, шийдвэр гаргаж ажиллана.

4.7. Мэргэжилийн байгууллага, хувь хүнээр дүгнэлт гэргуулах шаардлагатай тохиолдолд газрын даргад танилцуулна.